

“НОРДВИНД” ХХК

**ХЭНТИЙ АЙМГИЙН ГАЛШАР СУМЫН НУТАГТ ОРШИХ  
“ГАЛШАР”-ЫН ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ АШИГЛАХ  
ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АШИГТ МАЛТМАЛЫН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН

ДУГААР/ MV-011668/

/АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР/: (5003539)

Боловсруулсан: “Нордвинд” ХХК

2025 он УБ хот

## Гарчиг

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1. Төсөл хэрэгжүүлж буй засаг захиргааны харъяалал .....	2
1.2. Байгаль орчны төлөв байдал .....	4
1.2.1. Газар зүйн бүсчлэл .....	4
1.2.2. Цаг уур, уур амьсгалын тодорхойлолт .....	4
1.2.3. Ордын гидрогеологи .....	4
1.3. Уурхайн үндсэн мэдээлэл .....	5
1.3.1. Ордын нөөц .....	5
1.3.2 Уурхайн 2025 онд ажилласан байдал .....	5
ХОЁРДУГААР БҮЛЭГ. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН.....	6
2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	6
2.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт .....	7
2.3. Дүйцүүлэх хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....	9
2.4. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт .....	12
2.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....	12
2.6. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	13
2.7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт.....	14
2.8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөөний биелэлт .....	36
2.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын задаргаа .....	36

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төсөл хэрэгжүүлж буй засаг захиргааны харъяалал

**Төслийн нэр:** “ГАЛШАР” хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төсөл


**Төсөл хэрэгжүүлэгч:** “Нордвинд” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9019004024, Регистрийн дугаар: 5003539, Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл: MV-011668,

**Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:** Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1-р хороо, 4-40 тоот. Утас: 99110651

**Төслийн байршил:** Төсөл хэрэгжих талбай нь Хэнтий аймгаас зүүн урагш 90км, Бор-Өндөр дахь төмөр замын ертөөнөөс зүүн хойд зүгт 140км, Галшар сумын төвөөс 35 км зайд 54 га талбайг хамран оршино.


Хүснэгт №1 Төслийн талбайн солбицол

№	Уртраг	Өргөрөг
1	110° 59' 10.87"	46° 33' 45.69"
2	110° 58' 37.87"	46° 33' 45.69"
3	110° 58' 37.87"	46° 34' 10.7"
4	110° 59' 10.87"	46° 34' 10.7"




Зураг №1 Тусгай зөвшөөрлийн талбайн агаар сансрын зураг

ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙН БАЙРШИЛ



Зураг №2 Гал шар ордын байршил



Зураг №3 Тусгай зөвшөөрлийн талбайн хил заагийг харуулсан зураг

## **Засаг захиргааны харъяалал**

Судалгааны талбай нь Хэнтий аймгийн Галшар сумын нутагт, төмөр замын Бор-Өндөр өртөөнөөс зүүн хойш 120 км зайтай, Галшар сумаас хойш 40 км зайтай оршдог. Гадаргуугийн хувьд далайн түвшингээс дээш 1150-1230 м өргөгдсөн жижиг толгод, гүвээ, хэлбэрийн мөлгөржсөн хэсэгт багтан, говийн бүсийн эхлэлийн зааг хэсэгт оршдог. Орд орчимд далайн түвшингээс дээш 1420 м-т өргөгдсөн Бичигтийн Хар Өндөр овоо, Тагийн өндөр, Булштын өндөр зэрэг уулс нь харьцангуй залуу гүний чулуулгаас тогтох учир барзгар гадаргуутай, эргэн тойрон 20-50 км зайд харагдалт сайтай байдаг.

### **1.2. Байгаль орчны төлөв байдал**

#### **1.2.1. Газар зүйн бүсчлэл**

Урагшлах тутам газрын гадаргуу намсаж, мөлгөржин жижиг гүвээ, толгод болон хувирдаг ба харьцангуй өндөржилт нь 10-40 м-ээс хэтэрдэггүй. Тухайн дүүргийн гол онцлог нь тогтмол урсацтай гол горхи байдаггүй, зөвхөн Сайрын, Тагийн, Булштын, Хужиртын, Хушууны зэрэг жижиг булгуудтай, харин үүжим хөндийнүүддээ хужиртай жижиг шанд тойрмууд нэлээд элбэг, тэдгээрийн орчимд байрлах худгуудын ундарга нь 200-2600 л/цагт хэлбэлздэг боловч, ихэнх усны чанар нь ундны усанд тохиромж муутай байдаг.

#### **1.2.2. Цаг уур, уур амьсгалын тодорхойлолт**

Тухайн дүүрэг нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, улирлын ба хоногийн температурын хэлбэлзэл ихтэй, хур тунадас багатай, хуурай агаартай, цаг агаарын олон жилийн ажиглалтын (1938-1998) дунджаар хамгийн хүйтэн 12-1 сард болдог бөгөөд -230-240С, хамгийн халуун үе нь 6-8 сард +250+ 300 С орчим болдог. Жилийн дундаж хур тунадас 113 мм ба үүний дийлэнх хэсэг нь 6-9 сард (90мм) бороо хэлбэрээр буудаг байна. Салхи гол төлөв баруун хойноос зүүн урагш чиглэлтэй. Салхины жилийн дундаж хурд 4-7 м/сек гэх боловч хавартаа 20-40 м/сек хүрэх тохиолдол элбэг. Шимт хөрсний зузаан 5-20 см, цөөн тохиолдолд 40 см (нуур орчим) хүрдэг.

#### **1.2.3. Ордын гидрогеологи**

Тухайн дүүргийн гидрогеологийн онцлог нь тогтмол урсгалтай гол горхи байхгүй явдал юм. Зуны сүүлч, намрын цагт үргэлжилсэн бороо хурын дараа, ихэнх хөндийнүүдэд үер буун их хэмжээний хэмхдэс материал зөөгдөн ирж хуримтлагддаг.

Ус нь булингартай, хужирлаг, ундны усанд тохирдоггүй. Талбайн ойролцоо худаг элбэгтэй, томоохон худгуудаас Сайрын, Тагтын, Булштын, Хужиртын, Хушууны худгуудыг нэрлэж болно. Эдгээр худгуудын усны нөөц нь 500–600 сая литрээс 1500–2000 с.л, цөөн хэд нь 6900 с.л байдаг ба ундарга нь 200–2600 л/цаг байдаг. Эдгээрийн цөөн хэсэг нь ундны усанд тохирдог тул хүн ам нь усны гачаалтай байдаг. Судалгааны талбайн орчимд борооны усаар тэжээгддэг, ямар нэгэн урсгалгүй, хөндийн хонхор, хотгор даган үүссэн олон тооны давстай, ширгэдэг нуур тойром элбэг. Нууруудын эрэг дагуу намагтай, устай хэсэг нь голдуу дэрс, цахилдаг, ургасан байдаг ба нууруудын гүн нь 1.5–2.0 м-ээс хэтэрдэггүй. Харьцангуй том нуурууд нь Зүүн, Цавын нуурууд, Хярын тойром, Зураагийн тойром юм. Ус нь хужиртай. Усны нөөц нь бороо хур элбэгтэй жилүүдэд ихээхэн нэмэгддэг, техникийн усан хангамжид хүрэлцээтэй. Өвөлдөө цас


бага ордог, ихэнх хур тунадас нь зуны сүүлч, намрын үед ордог. Хавар зуны эхээр хуурайшилт ихтэй, салхитай байдаг учир ихэнх нүүр цөөрмүүд хэмжээгээрээ жижгэрч, зарим нь бүүр ширгэдэг.

### 1.3. Уурхайн үндсэн мэдээлэл

#### 1.3.1. Ордын нөөц

1959 онд ордыг Д.А.Лавров (0951ф) 2-р бүлгийн ордод хамруулсан байдаг. Ордын нөөцийг Уул уурхайн сайдын 2015 оны 09-р сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт матмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар”-ыг үндэслэн эдийн засгийн үр ашигтай нөөцийг бодитой (В) болон боломжтой (С) зэргээр тооцоолсон байна.

2015, 2017 онд Галшарын ордод хийсэн ажлын үр дүн, мөн 2009 оны Г.Мөнхзул нарын гүйцээх хайгуулын ажлын үр дүн (6095ф), 1956-1957 оны Д.А.Лавров нарын (0951ф) Галшарын ордын эрэл, хайгуулын ажлын тайлан, тооцоог ашиглан ордын үлдэгдэл нөөцийг орчин үед ашиглаж болох хүдрийн биетийн хэмжээс, агуулга, бусад үзүүлэлтүүдээс ашигтай хувилбарыг сонгон тооцоонд авч, хайлуур жоншны хүдэр ба эрдсийн нөөцийг одоо мөрдөгдөж байгаа заавар журам, техник, технологийн ололт, ТЭЗҮ-ийн тооцоо зэрэгт үндэслэн тооцсон.



Зураг №4 Хүдрийн биет 1-ийн босоо хавтгайд буулгасан нөөцийн тооцоо

#### Геологийн нөөц:

“Нордвинд” ХХК нь 2015-2017 онуудад MV-011668 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд орших хайлуур жоншны 1, 2, 2', 3-р хүдрийн биетүүдийн үлдэгдэл нөөцөд дахин тооцооллын ажлыг хийж, В зэрэглэлээр 110.6 мян.тн, С зэрэглэлээр 54.75 мян.тн, нийт В+С зэргээр 165.4 мян.тн хайлуур жоншийг улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна.

#### 1.3.2 Уурхайн 2025 онд ажилласан байдал

Гал шарын уурхайн хувьд 2025 онд 25.0 мян.тн хүдэр олборлож 30.0 мян.тн хүдэр баяжуулах төлөвлөгөөтэй байсан бөгөөд хөрөнгө оруулалттай холбоотой төлөвлөгөөт хүчин чадлаар ажиллаж чадаагүй.


## ХОЁРДУГААР БҮЛЭГ. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

### 2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөхдөө ТЭЗҮ-д тусгагдаагүй, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр авч үзвэл БОМТ-нд тусгаснаар төслийг хэрэгжүүлж ажилласан байна.

#### Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөлт

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх	Ажлын гүйцэтгэл	Баримтжуулалт
<b>1. АГААРЫН ЧАНАР</b>		
Ус шүрших	2025 онд уурхай нь 5-р сараас 11-р сарын сүүл хүртэл далд уурхайн нэвтрэлт болон олборлолтын ажил хийж гүйцэтгэсэн бөгөөд уурхайн налуу амнаас баруун тийш 55м зайд байрлах хоосон чулуулгийн овоолго хүртэл тоосжилтыг бууруулах зорилгоор өдөрт 1 удаа усалгааг хийж тоосжилтыг бууруулах ажил	Далд уурхайн нэвтрэлтийн ажил ид явагдаж байх үед 2025 оны 04 дүгээр сарын 30, 2025 оны 09-р сарын 27-ны өдөр тус тус Хэнтий аймгийн “Ус цаг уур орчны шинжилгээний төв”-ийн Байгаль орчны шинжилгээний лабораторийн эхлэгч, инженер Б.Ганганбайгаль, инженер Б.Шүрэнчимэг нар агаарын чанар болоод тоосжилтыг хамгийн их үүсэх магадлалтай газруудыг сонгож уурхай ам, баяжуулах үйлдвэр, авто пүү зэрэг газарт хэмжилт хийж үзэхэд хэвийн хэмжээнд байгааг шинжилгээгээр тогтоосон. Шинжилгээний сорьцын дүнг тайлангийн хуудас 15-17-д орууллаа.
<b>2. ХӨРСӨН БҮРХЭВЧ</b>		
Уурхайн эвдрэлд орсон талбайг хөрсөөр дүүргэж, шимд хөрсөөр хучна. Хучсан талбайг ургамалжуулах ажил хийгдэнэ.	2025 онд тусгай зөвшөөрлийн талбайн хойд захад 1.12 га талбай бүхий талбайд техникийн нөхөн сэргээлтийг үхсэн нүхийг булаах ажил хийгдсэн ба тухайн талбайг шимт хөрсөөр хучиж олон наст ургамлын үр цацаж усалгааны ажлууд хийгдсэн.	Тайлангийн 8р хуудсанд техникийн нөхөн сэргээлтийн ажлын тайлангийн фото зургийг орууллаа
<b>3. ГАДАРГЫН БОЛОН ГАЗАР ДООРХ УС</b>		
Байгальд хаях усны шинжилгээг тогтоосон хугацаанд хийж, хяналт тавьж холбогдох арга хэмжээг тухай бүр авах, хаях усыг тунааж ногоон байгууламжуудыг услах	Уурхайгаас шавхан зайлуулах усыг уурхайн 1-р босоо амны баруун урд 95м-ын зайд 60х40м-ын харьцаатай 5м-ын гүнтэй ус тунаах байгууламжийг байгуулан ажиллаа. Тухайн ус тунаах байгууламжаас хойш 45м байрлах ногоон байгууламжийн бүрэн услаад илүүдэл хэсгийг ил задгай урсгаж малчид ард иргэдийн мал услах задгай усны зориулалтаар уурхайн баруун урд талбай руу урсгалаа.	Тайлангийн 8-р хуудсанд хэмжилтийн ажлын тайлангийн фото зургийг орууллаа.
<b>2700.0</b>		



Зураг №5 Уурхайн хаягдал ус тунгаах байгууламж.

## 2.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

**Уурхайн ухашиг дүүргэх ажил:** Уурхайн ашиглалтын явцад эвдрэлд орсон 2-р босоо амны хойд хэсэгт 1.12 га талбай болон кемпийг тойрсон даланг хэсэгчлэн техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хаалтын үе шатанд тэгшлэн нягтаршуулж шимт хөрсөөр хучсан.


**Биелэлт:** Бичигт ордын төслийн талбайд нийт ашиглалтын хугацаанд үүссэн 13.1 га нийт эвдэрсэн талбайн байгаагаас хуучин ашиглаж байсан 2-р босоо амны хойно байрлах 1.12 га талбай болон кемпийг тойруулж зогон татсан хуучин нүхний 1.14 га талбайд техникийн нөхөн сэргээлт тус тус хийсэн.

Нөхөн сэргээсэн дээрх га талбайд олон наст ургамалын үр цацах болон хайлаас модны суулгац тарьж суулгах ажлыг зохион байгуулсан.

Цаашид төслийн талбайн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг үргэлжлүүлэн хийх болно.

### Хүснэгт 3. 2025 онд хийгдсэн нөхөн сэргээлтийн ажил

№	Үзүүлэлт	Талбай		Ажлын гүйцэтгэл
		Хэмжих нэгж	Тоон утга	
1	Техникийн нөхөн сэргээлт - Гадаад овоолго	га	2.26	2025 онд 2-р босоо амны хойд хэсэгт 1.12 га, кемпийг тойрсон үхсан нүхээр зогон татсан 1.14 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг үхсан нүхийг булаах ажил хийгдсэн. Нөхөн сэргээлт хийсэн талбайг геодези зураг зүйн үйлдвэрлэл үйлчилгээний Мэжор сүрвэй ХХК-иар хэмжилт хийлгэж талбайн хэмжээг тогтоов. Зураг №7,8,9,10,11,12
2	Биологийн нөхөн сэргээлт Шимт хөрс	га	0.87	Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайг шимт хөрсөөр хучин олон наст ургамалын үр цацаж биологийн нөхөн сэргээлт хийсэн ба мөн кемпийг тойрсон үхсан нүхийг дүүргэлт хийсэн талбайд зогон татсан 1500м <sup>2</sup> талбайд 800 ш хайлаас модны суулгац суулгасан зураг №14,15-д харууллаа.
3	Нийт нөхөн сэргээлт хийгдсэн талбай	Га	2.26	2025 оны нийт 2.26 га талбайд техникийн болоод биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж ажиллаа.



Зураг №6 2025 онд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай /2-р босоо амны хойно, кемпийн тойрсон зогон/




Зураг №7,8,9,10. 2025 онд үхсэн нүхийг дүүргэн техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай /Босоо 2-р амны хойно/

Биологийн нөхөн сэргээлт: Нийт техникийн нөхөн сэргээлт хийгдсэн талбайд шимт хөрсөөр хүчиж олон наст ургамалын үр цацаж, мод суулгах ажилд орон нутгийн саналыг

дүйцүүлэн хамгаалах арга хэмжээнд 0.9 га талбайд нийт 800 ш хайлаас модны суулгацыг харуулын байрны баруун зүүн талд суулгасан.

Хайлаас нь бүх байгалийн бүс бүслүүрт дасан зохицож ургадаг цорын ганц мод юм. Түүнээс гадна хайлаасны улиас зэрэг бусад том хэмжээний навчит модноос ялгарах гол онцлог нь таналт тайралт сайн даадаг тул тэдгээрийг эгнүүлэн суулгаад жил бүр засаж тайрч, ногоон хашлага болгож ургуулах боломжтой байдаг. Хайлаасны суулгацыг ургамлан хашлага, цөлжилттэй тэмцэх зэрэгт их хэмжээгээр хэрэглэгддэг.



Зураг №11. 2025 онд биологийн нөхөн сэргээлт хийгдсэн талбай /2-р босоо амны хойно, кемпийн тойрсон зогон/

### 2.3. Дүйцүүлэх хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Уурхайн талбайгаас баруун зүгт 2 км зайд байрлах орон нутгийн замын эвдрэлийг засварлах, мөн уурхайн урд зүгт байрлах “Гашууны гол”-ын гарамд орон нутгийн малчдын хэрэгцээнд зориулан гүүр барих ажлыг тус тус төлөвлөсөн бөгөөд Галшар сумын Засаг дарга болон орон нутгийн иргэдийн төлөөлөлтэй зөвлөлдсөний үндсэн дээр гүүр барих ажлыг мэргэжлийн байгууллагаар зураг, төслийг гаргуулж 2026 онд нэг мөр чанартай гүүр барихаар тохиролцсон.

Мөн Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд Галшар сумын Засаг дарга, Байгаль хамгаалагч нартай зөвшилцөж сумын төвөөс хойш 2 км зайд байрших “Ногоон байгууламж”-ийн 10 ширхэг хайсанд 400 ширхэг хайлаас мод суулгах ажлыг зохион байгуулсан.



Зураг №12,13,14,15. 2025 онд хайлаас модны суулгац суулгаж байгаа нь



Зураг №16,17. Уурхайн баруун талд 2км зайд байрлах борооны усны урсацаар эвдэрсэн зам. /Өмнөх болон нөхөн сэргээсэн байдал/

Тус компани нь “Умард говийн гүвээт-халхын дундад талын сав газрын захиргааны 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 249 тоот албан бичгээр ирүүлсэн “Усны нөөцийг бохирдож, хомстохоос хамгаалах, хамгаалалтын бүс, усны сан бүхий газрын хог хаягдлын цэвэрлэгээний ажлыг хийх төлөвлөгөө”-ний дагуу 2025 оны 10 дугаар сарын 18-ний өдөр Галшар сумаас хойш 7.5 км зайд байрлалтай “Арвингийн нуур” орчмын газрыг цэвэрлэх ажлыг зохион байгууллаа.



Зураг № 18.19. Арвин багийн нутагт байх “Арвингийн нуур”



Зураг № 20,21. Нуурын эрэг орчимд цэвэрлэгээ хийж байгаа байдлыг харуулав.



Зураг 22,23. Нуурын орчоос гарсан хогийг сумын төвийн төвлөрсөн хогийн цэгт хаяж буй байдал.

Цэвэрлэгээний ажилд тус компанийн 5 ажилчин, 1 тээврийн хэрэгсэл ажиллаж, АИ-92 33 л буюу 95.000 төгрөгийн шатахуун зарцуулсан болно.

Нуур орчмийн цэвэрлэгээний ажил зохион байгуулсан талаар сумын Засаг дарга Т.Энхчулуун, сумын Байгаль хамгаалагч С.Тогоохүү нарт биечлэн мэдэгдсэн болно.

#### 2.4. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Уурхай дээр тэсрэх бодисын агуулахтай. Холбогдох мэргэжлийн байгууллагуудаас зөвшөөрлийг авсан болно. Тэсрэх бодисын агуулах 5 тонны багтаамжтай бөгөөд эмульс ашигладаг. Тээвэрлэлтийг мэргэжлийн эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулж ажилладаг.

#### 2.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

“Нордвинд” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайд явуулж буй үйл ажиллагааны явцад палеонтологийн олдворын ул мөр болон археологийн дурсгал илрээгүй байна.

2025 онд Археологи, Палеонтологийн судалгааг хийлгэсэн.

**Палеонтологийн судалгаа:** Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн тавдугаар бүлгийн 27-р зүйлийн 8-д, Ашигт малтмалын тухай хуулийн 40<sup>1</sup>, 40<sup>2</sup>-р зүйлд заасны дагуу 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр Шинжлэх Ухааны Академийн-ийн Палеонтологийн хүрээлэнгийн байгууллагаас уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг “Нордвинд” ХХК-ийн Хэнтий аймгийн Галшар сумын нутаг дэвсгэрт орших ашигт малтмалын ашиглалтын “Бичигт” нэртэй MV-011668 дугаартай 54.23 га талбайд палеонтологийн хайгуул, судалгааг Шинжлэх Ухааны Академийн-ийн Палеонтологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Г.Алтаншагай, С.Хүрэлбаатар, Э.Мөнхтөр нар гүйцэтсэн.

Судалгааны талбайд мезозойн вулканоген чулуулаг, гуу жалгар орчин үеийн сэвсгэр хурдас түгээмэл тархсан гэх ба дөрөвдөгчийн настай чулуулагад эртний амьтан, ургамлын үлдвэр илрээгүй гэсэн дүгнэлт гарсан болно.



Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн тавдугаар бүлгийн 27-р зүйлийн 8-д, Ашигт малтмалын тухай хуулийн 40<sup>1</sup>, 40<sup>2</sup>-р зүйлд заасны дагуу 2025 оны 04 дугаар сарын 16-ны өдөр манай байгууллагаас уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг “Жеммери” ХХК-тай г/25-17 тоот ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан билээ. Тус гэрээний дагуу “Нордвинд” ХХК-ийн Хэнтий аймгийн Галшар сумын нутаг дэвсгэрт орших ашигт малтмалын ашиглалтын “Бичигт” нэртэй MV-011668 дугаартай 54.23 га талбайд палеонтологийн хайгуул, судалгааг Шинжлэх Ухааны Академийн-ийн Палеонтологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Г.Алтаншагай, С.Хүрэлбаатар, Э.Мөнхтөр нар гүйцэтгэв.

Судалгааны талбайд мезозойн вулканоген чулуулаг, гуу жалгар орчин үеийн сэвсгэр хурдас түгээмэл тархсан байна. Судалгааны талбайд тархсан дөрөвдөгчийн настай чулуулгаас эртний амьтан, ургамлын үлдвэр илрээгүй.

Хэдийгээр судалгааны талбайгаас палеонтологийн үлдвэр ажиглагдаагүй ч цаашдын ашигт малтмалын ашиглалтын үеэр, хүн болон байгалийн хүчин зүйлсийн нөлөөгөөр газрын гадаргад илрэх магадлал байгааг анхаарч ажиллах шаардлагатай. Ийнхүү ажиллахдаа судалгааны ажлын үр дүн болох “Палеонтологийн нөлөөллийн зураг”-ийг удиртгал болгохыг зөвлөж байна.

Ашигт малтмалын ашиглалттай холбоотой газар шорооны ажлын үеэр эртний амьтан, ургамлын үлдвэр илэрсэн тохиолдолд манай байгууллагатай яаралтай холбогдон авран хамгаалах ажлыг хамтран зохион байгуулахыг хүсье.

ЗАХИРАЛ



З.БАДАМХАТАН

1525000198

## 2.6. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хог хаягдлын менежментийг БОТБУ-ний хэсэгт тодорхойлон төлөвлөсөн байна.

### Хүснэгт 4. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Ажлын гүйцэтгэл
	1	2	3
1	Ахуйн	Ахуйн хаягдлыг ангилах дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авч байх	Хог хаягдал устгах үндсэн шийдэл нь булшлах арга бөгөөд төслийн хүрээнд үүсэх ахуйн бохир, хоол хүнсний хаягдлын хэмжээ бага байна. Тиймээс үйл ажиллагааны явцад ахуйн хатуу болон шингэн хаягдлыг хаягдлын санд булшлан гүйцэтгэсэн. Уурхайн талбайн гадна талд иргэдийн хаясан үхсэн малын сэг зэм, ахуйн хэрэглээний хаягдал хогийг цэвэрлэж, үхсэн нүхийг нөхөн сэргээх ажлыг хийж гүйцэтгэсэн. Уурхайн захиргаанаас сумын удирдлагуудтай уулзаж багийн малчин айл өрхийн хог хаягдлыг шийдвэрлэж өгөх талаар санал хүсэлт хүргүүлсэн. Энгийн хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдлыг түр хадгалах шаардлага хангасан хогийн бункерийг аймгийн төвд ажиглагдаж байгаа зураг дээрх загвараар хийлгэхээр захиалга өгсөн ба ахуйн хэрэглээний хог хаягдлыг ангилан ялгах, хадгалах шаардлага хангасан савыг байршуулсан.
2	Үйлдвэрийн	Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан ялган цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Аюултай хог хаягдлын үүссэн болон хуримтлагдсан хэмжээг нэр төрөл бүрээр бүртгэж, Химийн бодисын камержуулсан агуулахад хадгалж байгаа ба “Элемент” ХХК-тай 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдөр Химийн хортой болон аюултай бодисын хаягдал тээвэрлэх, устгах ажил гүйцэтгэх гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.
3.	Аюултай	Хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт өгөх	Аюултай хог хаягдал гараагүй.
4	<b>Нийт</b>		



Зураг №24,25. Энгийн хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах хогийн сав



**Зураг №26, 27. Хог хаягдлыг ашиглалтын талбайн гадна талд нүх ухаж хаясан орчмыг цэвэрлэх, нүхийг булж нөхөн сэргээж буй байдал**



**Зураг №27,28. Төслийн талбайд байрлах нүхэн жорлонг Нүхэн жорлон, угаадасны нүх**

Хүний эрүүл мэнд хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах түүнээс урьдчилан сэргийлэх ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, дахин боловсруулж эргүүлэн ашиглах, тээвэрлэх бүүлгах болон орчны ариун цэврийг тогтмол цэвэр байлгах, цэвэр эрүүл орчинд ажиллах амьдрах орчныг бий болгох ажлын хүрээнд Хэнтий аймгийн Галшар сумын засаг даргатай хамтран ажиллах гэрээг байгуулан ажилласан.

### **2.7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт**

Тус компани нь 2025 онд уурхайн төслийн талбайн тохижилт үйлчилгээг сайжруулах ажилд онцгой анхаарч, ажилчдын ажиллаж амьдрах нөхцөл бололцоог хангах зорилгоор хуучин ашиглаж байсан ажилчдын амрах байрыг шинэчлэн 34 ширхэг угсармал сууц байршуулж, нэгдсэн халаалт, цэвэр, бохирын шугамд холбох ажлыг хийж гүйцэтгэсэн.

Нийгмийн хариуцлагын хүрээнд Хэнтий аймгийн Засаг дарга Д.Аюурбунь, Галшар сумын Засаг дарга Т.Энхчулуун нартай хамтран ажиллах гурвалсан гэрээг 2025 оны 09 сард 4 жилийн хугацаатай байгуулж гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тус гэрээнд тусгагдсан 20.000.000 төгрөгийг Хэнтий аймгийн “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн 10090100180052400 тоот дансанд 2025 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр байршуулсан. Мөн сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээг 2025 оны 8 сард байгуулж гэрээний хавсралтад тусгагдсан суманд шаардлагатай ажил, арга хэмжээний жагсаалтын дагуу 40.000.000 /Дөчин сая/ төгрөгийг шилжүүлж хамтран ажиллаж байна.

## 2.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

## Хүснэгт 5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Хяналт-шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Гүйцэтгэл
<b>Агаарын чанар</b>		
SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , CO, Тоос, цацраг	Уурхайн гол ам, баяжуулах үйлдвэрийн орчим салхин доод талд, 3 орчим цэгт	Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораториор 2025 оны 04 дүгээр сарын 30, 2025 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр тус тус шинжилгээний сорьц авхуулсан.
<b>Газар доорх ус</b>		
Усны чанарын стандартад заасан үзүүлэлтүүд	Ашиглаж буй уст цэгүүдэд	<p>Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораториор 2025 оны 04 дүгээр сарын 30, 2025 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр тус тус уурхайн шавхан зайлуулалтын гүний худаг болон унд ахуйд хэрэглэж буй уснаас шинжилгээний сорьц авхуулж, аймгийн Эрүүл мэндийн газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчаар хими судлалын шинжилгээ хийлгэсэн.</p> <p>Уг шинжилгээгээр Хүрээлэн буй орчин, Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандартын шаардлага хангасан дүгнэлт гарсан.</p>
<b>Хөрсөн бүрхэвч</b>		
Хөрсний хүнд металлын бохирдол Pb, Cd, Cr, Zn, Ni,	Хөрс уурхайн далан	Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораториор 2025 оны 04 дүгээр сарын 30, 2025 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр тус тус шинжилгээний сорьц авхуулсан.



УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ

Хэнтий аймаг Хэрлэн сум 2-р баг тэмүүжингийн  
гудамж Н-13  
Утас/Факс: 93028611, 98092200  
E-mail хаяг: mnhe\_oper@yahoo.com



Сорьцын дугаар: 01  
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: "Нордвинд" ХХК карьер  
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: БОШЛ-н инженер Б.Шүрэнчимэг  
Сорьцын төрөл тоо, хэмжээ: Цацраг  
Сорьц авсан огноо: 2025-04-30  
Лабораторид хүлээж авсан : 2025-04-30  
Шинжилгээ эхэлсэн огноо: 2025-04-30  
Хэвлэсэн огноо: 2025-05-10  
Хуудасны тоо: 1/1

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Шинжилгээний аргын стандартууд	Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж /мг/л/	Хүлцэх агууламж	Үр дүн /мг/м <sup>3</sup> /
САЗ А04	Цацраг - агаар мкЗв/цаг	-	0.11
	Цацраг -хөрс мкЗв/цаг	-	0.15

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:  
БОШЛ-Н ЭРХЛЭГЧ ИНЖЕНЕР: *[Signature]* /Б.ГАНГАНБАЙГАЛ /  
ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦӨТГӨСӨН:  
БОШ ЛАБОРАТОРИЙН ИНЖЕНЕР: *[Signature]* /Б.ШҮРЭНЧИМЭГ /

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна.



УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ

Хэнтий аймаг Хэрлэн сум 2-р баг тэмүүжингийн  
гудамж Н-13  
Утас/Факс: 93028611, 98092200  
E-mail хаяг: mnhe\_oper@yahoo.com



Сорьцын дугаар: 02  
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: "Нордвинд" ХХК баяжуулах үйлдвэр  
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: БОШЛ-н инженер Б.Шүрэнчимэг  
Сорьцын төрөл тоо, хэмжээ: Цацраг  
Сорьц авсан огноо: 2025-04-30  
Лабораторид хүлээж авсан : 2025-04-30  
Шинжилгээ эхэлсэн огноо: 2025-04-30  
Хэвлэсэн огноо: 2025-05-10  
Хуудасны тоо: 1/1

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Шинжилгээний аргын стандартууд	Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж /мг/л/	Хүлцэх агууламж	Үр дүн /мг/м³/
САЗ А04	Цацраг - агаар мкЗв/цаг	-	0.12
	Цацраг -хөрс мкЗв/цаг	-	0.16

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:  
БОШЛ-Н ЭРХЛЭГЧ ИНЖЕНЕР:  /Б.ГАНГАНБАЙГАЛ /  
ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:  
БОШ ЛАБОРАТОРИЙН ИНЖЕНЕР:  /Б.ШҮРЭНЧИМЭГ /

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна.



УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ  
ЛАБОРАТОРИ



Хэнтий аймаг Хэрлэн сум 2-р баг  
Тэмүүжингийн гудамж Н-13  
Утас/Факс: 93028611, 98092200  
E-mail хаяг: mnhe\_oper@yahoo.com

Сорьцын дугаар: 3  
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: “Нордвинд” ХХК хяналтын цэг  
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: БОШЛ-н инженер Б.Шүрэнчимэг  
Сорьцын тоо, хэмжээ: 300г  
Сорьцын төрөл: хөрс  
Сорьц авсан огноо: 2025-04-30  
Лабораторид хүлээж авсан : 2025-04-30  
Шинжилгээ эхэлсэн огноо: 2025-04-30  
Хэвлэсэн огноо: 2025-06-10  
Хуудасны тоо: 1/1

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж		Хүлцэх агууламж	Үр дүн
MNS3310:1991	Орчин- рН	-	8.1
MNS3310:1991	Чийг - %	-	6.2 %
MNS3310:1991	Ялзмаг	-	1.2
MNS3310:1991	Аммиак- NH <sub>4</sub> мг / л	-	2.5
MNS3310:1991	Нитрат – NO <sub>3</sub> мг / л	-	8.2
MNS3310:1991	Сульфат- SO <sub>4</sub> мг / л	-	175.2
MNS3310:1991	Фосфор (P <sub>2</sub> O <sub>5</sub> ) мг / л	-	39.8

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:  
БОШЛ-Н ЭРХЛЭГЧ ИНЖЕНЕР: *[Signature]* /Б.ГАНГАНБАЙГАЛ /  
ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:  
БОШ ЛАБОРАТОРИЙН ИНЖЕНЕР: *[Signature]* /Б.ШҮРЭНЧИМЭГ /

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна.



УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ  
ЛАБОРАТОРИ

Хэнтий аймаг Хэрлэн сум 2-р баг  
Тэмүүжингийн гудамж Н-13  
Утас/Факс: 93028611, 98092200  
E-mail хаяг: mnhe\_oper@yahoo.com



Сорьцын дугаар: 5  
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: **“Нордвинд” ХХК** баяжуулах үйлдвэрийн зүүн урд 100метр  
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: БОШЛ-н инженер Б.Шүрэнчимэг  
Сорьцын тоо, хэмжээ: 300г  
Сорьцын төрөл: хөрс  
Сорьц авсан огноо: 2025-04-30  
Лабораторид хүлээж авсан : 2025-04-30  
Шинжилгээ эхэлсэн огноо: 2025-04-30  
Хэвлэсэн огноо: 2025-06-10  
Хуудасны тоо: 1/1

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж		Хүлцэх агууламж	Үр дүн
MNS3310:1991	Орчин- рН	-	7.0
MNS3310:1991	Чийг - %	-	8.0 %
MNS3310:1991	Ялзмаг	-	12.5
MNS3310:1991	Аммиак- NH <sub>4</sub> мг / л	-	4.8
MNS3310:1991	Нитрат – NO <sub>3</sub> мг / л	-	15.7
MNS3310:1991	Сульфат- SO <sub>4</sub> мг / л	-	50.4
MNS3310:1991	Фосфор (P2 O5) мг / л	-	43.8

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:  
БОШЛ-Н ЭРХЛЭГЧ ИНЖЕНЕР: *[Signature]* /Б.ГАНГАНБАЙГАЛ /  
ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭГЛЭСЭН:  
БОШ ЛАБОРАТОРИЙН ИНЖЕНЕР: *[Signature]* /Б.ШҮРЭНЧИМЭГ /



Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна.



УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ  
